

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН “2020-2024” ОНЫ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

**ОРШИЛ**

Монгол улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Сум дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг дарга томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна” гэсэн заалтыг үндэслэж сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

Энэхүү бодлогын баримт бичгийг Алсын хазраа – 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Баянжаргалан 100 хөгжлийн хөтөлбөрийн 3 дугаар шат, мөн иргэд олон нийтийн саналд үндэслэн боловсрууллаа.

Уг бодлогын баримт бичигт иргэд олон нийтийн саналыг тусгахдаа Баянжаргалан цахим хуудсаар саналыг авсан. Тус хөтөлбөрт тусгуулахаар 16 иргэн, албан хаагчдаас 41 санал ирүүлсэнийг холбогдох байгууллага, мэргэжилтэн нар хөтөлбөрт тусгахад хэрэгжих боломжийг судлан тусган ажилласан.

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлсэн, орон нутгийн нөөцөд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийг чухалчилна.

**ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ:**

Энэхүү хөтөлбөрөөр тодорхойлсон зорилго, зорилтуудыг үе шаттай хэрэгжүүлж, сумынхаа ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахын тулд дараах нэгдмэл зарчмуудыг удирдлага болгон хэрэгжүүлж ажиллах болно. Үүнд:

- ✓ Ардчилсан, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах
- ✓ Сумынхаа хөгжилд иргэн бүр хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцлийг бүрдүүлэх
- ✓ Төрийн болон төрийн бус байгууллага бизнесийн түншлэлд суурьлан хамтын ажиллагааг бэхжүүлэх
- ✓ Бүх шатанд хариуцлага хүлээх чадвар, ил тод байх явдлыг хэм хэмжээ болгон ажиллана.

## ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМ:

- Ковид -19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого
- Хүний хөгжлийн бодлого
- Сайн засаглалын бодлого
- Хөдөө аж ахуйн бодлого
- Эдийн засгийн бодлого
- Ногоон хөгжлийн бодлого
- Орон нутгийн хөгжлийн бодлого

### НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

- Ковид – 19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэн, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах

### ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- Эрүүл мэнд
- Эрүүл, идэвхтэй амьдралтай иргэн
- Боловсрол
- Үндэсний бахархал өв, соёл урлаг
- Ажилтай, орлоготой иргэн
- Ахмад, залуучууд, эмэгтэйчүүд, хүүхэд, гэр бүлийн хөгжил

### ГУРАВ. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- Хүнд сурталгүй -цахим Баянжаргалан
- Мэргэшсэн чадварлаг, хариуцлагатай төрийн алба
- Хүний эрхийг дээдэлсэн амар, тайван аюулгүй нийгэм
- Гадаад бодлого
- Батлан хамгаалах
- Шилэн тендерийг зохион байгуулна.

### ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- Малчдын амьжиргааг сайжруулна.
- Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулна.
- Бэлчээрийн менежментийг сайжруулна.

### ТАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- Санхүү, төсвийн зохицуулалт
- Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.
- Төр, хувийн хэвшлийн түншлэл.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- Уул уурхай, хүнд үйлдвэр

### ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.

#### ДОЛОО. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- Гэр хорооллын дахин төлөвлөлт
- Суманд хийгдэх хөрөнгө оруулалт

#### НАЙМ. АЖИЛТАЙ, ОРЛОГОТОЙ ИРГЭН

- Ажилгүй иргэдийг ажлын байраар хангаж, орлогыг нэмэгдүүлэх

## НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО

Зорилго. “КОВИД-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэн, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлж, төсөв санхүүг оновчтой зохион байгуулан, бэлэн байдлыг тогтмолжуулна.

Зорилт: 1. “Ковид-19” халдварт цар тахал шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ:

1.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ариун цэврийн дэглэм, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг зохион байгуулна.

1.2. Шинэ болон дахин сэргэж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэд, олон нийт болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, шаардлагатай дадлыг хэвшүүлж, чадавхжуулна.

1.3. Ковид-19 цар тахалаас урьдчилан сэргийлэх цахим сургалтанд иргэд малчдыг хамруулж үр нөлөөг дээшлүүлж мэдлэг дадал олгоно.

1.4. Зорилтот бүлгийн иргэдийг томуугийн эсрэг дархлаажуулалтад үе шаттайгаар хамруулна.

1.5. Төрийн албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулна.

Зорилт: 1.2. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.

Арга хэмжээ:

1.2.1. Эрүүл мэндийн байгууллагын хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.

1.2.2. Шуурхай арга хэмжээний хамтарсан багийг чадавхжуулан, ажиллах нөхцөл, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулна.

1.2.3. Тусгаарлах өрөөний орчин нөхцлийг сайжруулж стандартад нийцүүлнэ.

1.2.4. Санхүүжилт, хандив

1.2.5. Ковид – 19 цар тахалт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд иргэдийг хамруулах

## ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

### Эрүүл мэнд

Зорилго: Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношлогоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

Зорилт 2.1 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ

2.1.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэн бүр /зорилтот бүлгийн иргэд/ эрт илрүүлгийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.1.2. Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлнэ.

2.1.3. “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлж эрүүл мэндийн зөв мэдлэг дадлыг төлөвшүүлж, халдварт бус өвчнийг илрүүлэх “явуулын үзлэг”-т иргэдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

2.1.4. “Тэмбүүгүй Дундговь” аяны хүрээнд сумын нөхөн үржихүйн насны эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүсийг хамруулна.

2.1.5. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний хүрээнд эх баригч болон хүүхдийн эмчийг мэргэшүүлэх сургалтад хамруулна.

2.1.6. “Хавдрын эсрэг” арга хэмжээг хэрэгжүүлж хавдрын эрт илрүүлэг, үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

2.1.7. “Элэг бүтэн Монгол” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж оношилгоо, эмчилгээний хамрагдалтыг сайжруулна.

2.1.8. “Эрүүл шүд” арга хэмжээг хэрэгжүүлж, амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүлжүүлэлтийг нэмэгдүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дадлыг олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.

2.1.9. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд архи тамхины хэрэглээг бууруулах, дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, эрүүл зөв хооллолтын дадал хэвшлийг бий болгоно.

2.1.10. Сэтгэл зүйч эмчтэй болж кабинет байгуулах

2.1.11. Багийн эмч нарыг унаажуулах

Зорилт 2.2. Орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Арга хэмжээ

2.2.1. Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, автомашины шинэчлэлийг хийж тусламжийн чанар хүртээмжийг сайжруулна.

2.2.2. Эрүүл мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийн хангалтыг шат дараатай нэмэгдүүлж, сум орон нутагтаа оношлуулж эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.2.3. Сумын Эрүүл мэндийн төвд эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн өрөөг шинэчлэн тоног төхөөрөмжөөр хангана.

2.2.4. Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах эмчилгээний нэр төрлийг олшруулах, орны тоо шинээр үүсгэх, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.

2.2.5. Нөхөн сэргээх, асаргаа, сувилгааны танхимтай болох

Зорилт 2.3. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ

2.3.1. Иргэдийн эрүүл мэндийн цахим мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээ авна.

2.3.2. Анхан шатлалд явуулын болон алсын зайн тусламж үйлчилгээний цахим технологийг нэвтрүүлж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 2.4. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ

2.4.1. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой аргыг нэвтрүүлнэ.

2.4.2. Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ

2.5.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг хангуулна.

2.5.2. Шинэчлэгдсэн цахим жорын программыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5.3. Шинэчлэгдсэн цахим жорын программыг өргөжүүлж, эрүүл мэндийн даатгалын сангийн үнийн хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.6. Эрүүл мэндийн ажилтны хөгжил, нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах, хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх нөхцөл боломжоор хангана.

Арга хэмжээ

2.6.1. Эмч, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын ахисан түвшиний сургалтад хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлнэ.

2.6.2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулан тогтвор суурьшилтай ажиллуулах эдийн засгийн хөшүүргийг оновчтой, хүртээмжтэй болгоно.

2.6.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Эрүүлжин хөгжих төв”-ийн үйлчилгээнд хамруулна.

Эрүүл идэвхтэй амьдралтай иргэн:

Зорилго: Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, тамирчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Зорилт: 2.7. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан бодлогыг хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ:

2.7.1 Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг дэмжиж төр, хувийн хэвшлийн олон талт оролцоог дэмжиж хамтран ажиллана.

2.7.2. “Унадаг дугуй” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.7.3. “Нийтийн биеийн тамир”-ын спортын олон төрөлт арга хэмжээг жил болгон зохион байгуулна.

2.7.4. Хурдан морины уралдаан, сур, шагайн харваа, үндэсний бөх, шатар, даам зэрэг спортын төрлүүдийг дэмжиж, дугуйлан секц ажиллалуулахад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.7.5. Үндэсний өв соёл, уламжлалт спортыг хөгжүүлэх “Монгол бахархал” арга хэмжээг зохион байгуулна.

2.7.6. Спортын төрлүүдээр улс, бүсийн чанартай тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна.

2.7.7. Улс, бүс, аймаг, сумдын чанартай тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлнэ.

2.7.8. Шинээр төрөн гарсан спортын алдартнуудын олон төрөлт тэмцээн зохион байгуулж, тамирчдад хүндэтгэл үзүүлнэ.

2.7.9 “Эрүүл идэвхтэй амьдрах клуб” бий болгоно.

**Боловсрол**

**Ерөнхий боловсролын сургууль:**

Зорилго: Хүн бүрт чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилт: 2.8. Хүн бүрт чанартай тэгш боломж бүрдүүлж боловсролыг гэр бүлийн сум орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

2.8.1. Ажлын байрны мэргэшүүлэх сургалтанд төрийн албан хаагчдыг хамруулна.

2.8.2 Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэж мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэнэ.

2.8.3 Насан туршийн нэгжээрээ дамжуулан 8-9-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулна.

2.8.4 Насан туршийн боловсролын төвийн ажиллах нөхцөлийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалт арга хэмжээнд хамруулах

2.8.5 Иргэдийн боловсролыг дээшлүүлэх төрөл бүрийн сургалт зохион байгуулж, туршлага судлуулна.

Зорилт 2.9. Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангаж, мэргэжилтэй ажилтны эзлэх хувь 2020 онд 40 хувь байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

2.9.1 Соёлын байгууллагын ажилтнуудыг үе шаттайгаар сургаж, чадварлаг мэргэжлийн хүний нөөцөөр хангана.

Зорилго: Өв уламжлал түүх соёлоо дээдлэн, хүн бүрт чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлж сурлагын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ.

Зорилт: 2.10. Боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ:

2.10.1. Сургуульд 6 настай хүүхдийг 100 хувь элсүүлэн сургана.

2.10.2. Малчдын хүүхдийг дотуур байраар 100 хувь хангана.

2.10.3. Сургуулийн сурагч, багш нарын үндэсний үнэлгээний чанарыг ахиулна.

2.10.4. Байгаль орчин, шинжлэх ухаан, танин мэдэхүйн олон талт арга хэмжээнд хүүхдүүдийг өргөнөөр хамруулан орон нутгийн түүх, соёлыг таниулах зорилгоор “Түүхийн дурсгалт газруудаар аялацгаая” сэдэвт арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

2.10.5. Хүүхдийн урлаг спортын наадам зохион байгуулна.

2.10.6. Бага боловсролын хамран сургалтын хувийг 2020 онд 79.6%, суурь боловсролын хамран сургалт 77.4% байсныг 2024 онд бага боловсролын хамран сургалтыг 98%, суурь боловсролын хамран сургалтын хувийг 82%-д тус тус хүргэнэ.

- 2.10.7. "Чадварлаг багш - Чанартай боловсрол" арга хэмжээ зохион байгуулна
- 2.10.8. Орон нутагт нэн шаардлагатай багш нарын судалгааг гаргаж мэргэжлийн боловсон хүчнээр хангахад анхаарч ажиллана.
- 2.10.9. Багшийн хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, багшийн хөгжлийн төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэнэ
- 2.10.10. Сургуулийн дуу хөгжмийн кабинет болон мэргэжлийн хичээлийн кабинетыг тохижуулан гэрчилгээтэй кабинетын тоог нэмэгдүүлнэ.
- 2.10.11. Сургууль, дотуур байр, спорт заалны гадаад дотоод засвар үйлчилгээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.
- 2.10.12. Сургууль, дотуур байрыг түшиглэн “Хүүхэд хөгжлийн төв”-ийг бий болгоно.
- 2.10.13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхимыг насан туршийн боловсролын өрөөг түшиглэн байгуулна.
- 2.10.14. Байгалийн ухааны, мэдээлэл технологийн танхимын тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
- 2.10.15. Цахим номын сантай болж, номын фондыг нэмэгдүүлэн номын сангийн орчинг сайжруулах
- 2.10.16. Биеийн тамирын гадаад талбайг стандартын дагуу тохижуулна.
- 2.10.17. Сургуулийн гал тогооны хоолны заалны ширээ сандлыг шинэчлэн сайжруулна.
- 2.10.18. Сургууль, дотуур байрыг ундны усны шүүлтүүрээр хангана.
- 2.10.19. Сургуулийг цахим сургууль болгох шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 2.10.20 Жил бүр сургууль, цэцэрлэгийн шилдэг багш, ажилчдыг шалгаруулж, багш нарын баярыг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж, нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцлийг сайжруулах
- 2.10.21 Багш нарын ур чадвар, сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаан, сурагчдын дунд мэргэжлийн хичээлүүдийн олимпиад зохион байгуулна.
- 2.10.22 Гадаад хэл, байгалийн ухааны багш нар, бусад мэргэжлийн багш нарын мэргэжлийг дээшлүүлнэ.
- 2.10.23 Сургууль, дотуур байр, спорт заалны ариун цэврийн байгууламж, дотор нойлын засварын ажлыг хийж гүйцэтгэх
- 2.10.24 . Эмчийн өрөөг шинээр тохижуулан сургуулийн эмчтэй болно.
- Зорилт: 2.11 Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.
- Арга хэмжээ
- 2.11.1 “Үндэсний бичиг-2025” олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.11.2 Монгол хэл, бичгийн аймаг, улсын олимпиад, уралдаан тэмцээнд оролцоно.



2.11.3. Иргэдэд зориулсан үндэсний бичгийн танхимын үйл ажиллагааг иргэний танхимыг түшиглэн тогтмолжуулна.

2.11.4 Төрийн албан хаагчдын модуль сургалтын кредитийг тооцон урамшуулал олгоно.

2.11.5 Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, танилцуулга, нэрийн хуудас, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг монгол бичгээр бичиж хэвшүүнэ.

### **Хүүхдийн цэцэрлэг:**

Зорилт: 2.12. Өв уламжлал түүх соёлоо дээдлэн, хүн бүрт чанартай боловсрол эзэмших боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлж хамраан сургалтыг 77 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ

2.12.1. Сургуулийн өмнөх боловсролд 2-5 настай хүүхдийг хамруулж, 5 настай хүүхэд бүрийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.

2.12.2. 1-2 настай хүүхдийг яслийн бүлгийг стандартын дагуу тохижуулан нээн ажиллуулах

Зорилт: 2.13. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.

Арга хэмжээ

2.13.1. Багш нарын дунд урлаг спортын олон талт үйл ажиллагааг зохион байгуулан шилдэг багш нарыг шалгаруулан багш нарын баярыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах

2.13.2. Цэцэрлэгийн багшлах боловсон хүчнээр хангаж багш нарын ниймгийн хангамжийг сайжруулж, мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад үе шаттайгаар хамруулж, туршлага судлуулах

Зорилт: 2.14. Боловсролын байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг сайжруулна.

Арга хэмжээ

2.14.1. Цэцэрлэгийн хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулж багшийн хөгжлийн төвийг тохижуулна.

2.14.2. Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын танхимыг стандартын тоног төхөөрөмжөөр хангана.

### **Үндэсний бахархал өв, соёл урлаг**

Зорилго: Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдлэн, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

Зорилт: 2.15 Стандарт шаардлагад нийцсэн соёл урлагийн байгууллагын барилга байгууламжийн тоог нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулж, чанартай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлээр хангана.

2.15.1 Орон нутгийг судлах танхимыг байгуулан тохижуулна.

2.15.2 Орчин үеийн тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хувцас хэрэглэлийг нэмэгдүүлнэ.

2.15.3 Номын санг тохижуулах.

2.15.4 Явуулын иж бүрэн тоноглогдсон машинтай болох.

Зорилт: 2.16 Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, орон нутгийн онцлог шингэсэн соёлын үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.

2.16.1 Баянжаргалан сумаас төрөн гарсан урлаг, соёлын алдартнуудын бүтээл туурвилуудыг олон нийтэд түгээх, сурталчилан таниулах, нутагшуулах, алдаршуулах ажлыг зохион байгуулж, тэмдэглэлт ой, томоохон арга хэмжээнд зориулсан уран бүтээл, арга хэмжээг дэмжиж ажиллана.

2.16.2 “Авъяаслаг Жаргаланчууд” урлагийн наадмыг зохион байгуулна.

2.16.3 Сумын хүүхэд залуучуудын оролцоонд түшиглэн морин хуур, уртын дуу, үндэсний хөгжим, утга зохиол, яруу найраг, дуу, бүжгийн олон төрөлт сургалт, дугуйланг тогтмолжуулж, хүүхэд залуучуудын авьяас билгийг хөгжүүлж, уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.16.4 Нүүдлийн соёл иргэншлийн уламжлалт хэв шинжийг орчин үеийн хөгжлийн чиг хандлагатай хослуулан, нутгийн брэнд болсон боржигон уртын дуу, морин хуур, боржигон соёлын өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх “МИНИЙ НУТАГ-БОРЖИГОН НУТАГ” хөтөлбөрийг өвлөн уламжлагч болон албан байгууллагууд, иргэдийн оролцоонд суурилан хэрэгжүүлнэ.

2.16.5. Номын санд “Үүлэн технологи” электрон каталогийг нэвтрүүлж, техникийн дэвшлийг сайжруулан номын фондыг баяжуулна.

Зорилт: 2.17 Нүүдлийн өв соёл, ёс заншил, уламжлалыг түгээн дэлгэрүүлж, сурталчилан таниулна.

2.17.1 Соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, шинээр илрүүлэх, судлан сэргээх, бүртгэлжүүлэх, өвлөн уламжлуулах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчилан таниулах, алдаршуулах ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.

2.17.2 Албан байгууллага, ААН, ард иргэдийн гар дээрх хөдлөх дурсгал буюу үзмэр, эд өлгийн зүйлсээр музейн сан хөмрөгийг баяжуулах ажлыг зохион байгуулна.

2.17.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, шийдвэр гаргуулах

2.17.4 Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгийг хөтлөх үндэсний уламжлалыг хэвшүүлэх зан үйлийг сургах, сургалт нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлж, сумын нийт өрхийн 50-аас доошгүй хувийг угийн бичиг хөтөлдөг болгоно.

2.17.5 Угийн бичиг хөтлөлтийн ажлын үр дүнг тусгай болзол, журмын дагуу дүгнэж, урамшуулна.

## **Нийгмийн даатгал:**

Зорилт: 2.18. Нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөтгөж, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ.

Арга хэмжээ:

2.18.1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.18.2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч болон даатгуулагчийн тоог нэмэгдүүлнэ.

2.18.3. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын орлогыг бүрдүүлнэ.

### **Ахмад, залуучууд, эмэгтэйчүүд, хүүхэд, гэр бүлийн хөгжил**

Зорилт: 2.19. Ахмадад ээлтэй байгууллагын санал санаачлагыг дэмжинэ.

Арга хэмжээ:

2.19.1. Албан байгууллагуудаас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад нийгмийн баталгааг дэмжих, дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

2.19.2. Ахмад настан, залуучуудын гурван үеийн “Алтан хэлхээ” уулзалтыг зохион байгуулна.

2.19.3. Ахмадын өргөө барьж үйл ажиллагааг нь жигдрүүлнэ.

2.19.4. “Хаан аав, хатан ээж” ахмад настныг алдаршуулна.

2.19.5. Ахмадуудын урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна.

Зорилт: 2.20 Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

2.20.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд залуучуудын оролцоог хангана.

2.20.2. Залуучуудын чуулган зохион байгуулна.

Зорилт: 2.21. Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн оролцоог хангана.

Арга хэмжээ:

2.21.1 “Эмэгтэйчүүдийн манлайлал” зөвлөгөөн зохион байгуулна.

Зорилт: 2.22 Хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.

Арга хэмжээ:

2.22.12.22.2. “Хүүхдийн урлан бүтээх дугуйлан” байгуулна.

2.22.3. Сумын хүүхдийн сан байгуулна.

2.22.4. Сумын хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг чадавхжуулах цогц арга хэмжээ нөлөөллийн сургалтыг зохион байгуулна.

Зорилт 2.23. Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.

Арга хэмжээ:

2.23.1.

2.23.2. Гэр бүл, хүүхэд, залуучуудын байртай болж иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчинг бүрдүүлнэ.

### **ГУРАВ. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

Зорилго: 3. Хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой, сайн засаглалыг бэхжүүлэн, цахим технологид тулгуурласан төрийн үйлчилгээг эрчимжүүлж, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

#### **Хүнд сурталгүй цахим Баянжаргалан**

Зорилт: 3.1 Төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлнэ.

Арга хэмжээ:

3.1.1 Төрийн байгууллагуудад цахим хэрэглээг үе шаттай нэвтрүүлж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулна.

3.1.2 Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулан хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.3 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг сайжруулж иргэд олон нийтийн оролцоог хангана.

3.1.4 Архивыг нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

#### **Мэргэшсэн, чадварлаг төрийн алба**

Зорилго: Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчилгүй ажиллана.

Зорилт 3.2. Төрийн бодлогын залгамж чанарыг ханган, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ.

3.2.1. Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчилгүй ажиллана.

3.2.2 Дутагдалтай байгаа салбарын мэргэжилтэнийг сургаж хүний нөөцийг бэлтгэнэ.

3.2.3 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтанд хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлнэ.

3.2.4. Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд олон нийтийн оролцоотой хамтран хэрэгжүүлнэ.

3.2.5. Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Тэргүүний төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах арга хэмжээ зохион байгуулах

3.2.6 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяалалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.2.7. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.

### **Хүний эрхийг дээдэлсэн амар тайван аюулгүй нийгэм**

Зорилго. Иргэдийн аюулгүй, амар тайван орчинд, ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Зорилт: 3.3 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

Арга хэмжээ:

3.3.1. Сумын хэмжээнд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн судалгааг гаргаж үнэлэлт, дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн онцлог, хүн ам, гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдалд тохируулан ажил, арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

3.3.2. Сумын хэмжээнд ашиглаж байгаа хяналтын камерын судалгааг нарийвчлан гаргаж, ашиглалтыг сайжруулан, засвар үйлчилгээг хийж, шаардлагатай цэгүүдэд нэмж камер байрлуулах, сумын төвд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг камерын хяналтаар илрүүлж, урьдчилан сэргийлж ажиллах.

3.3.3. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хуулийг иргэдэд сурталчилан таниулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор сургалтыг хамтарсан багийн гишүүдийн оролцоотойгоор, үе шаттай зохион байгуулна.

3.3.4. Сумын малчин иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, малчдын бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, чиглэлээр ажил арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, мал хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, бүлэг нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зааварчлан, удирдлагаар хангаж ажиллана.

3.3.5. Зам тээврийн осол гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарсан шалгалтыг тогтмол зохион байгуулна.

3.3.6. Сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажилчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалтыг зохион байгуулж ажиллана.

3.3.7. Архидан согтуурах, архины хор хөнөөл, хор уршигийн талаар иргэдэд нөлөөллийн сургалт сурталчилгааг тогтмол хийж АРХИГҮЙ ДУНДГОВЬ хөтөлбөрийг салбар төлөвлөгөөний дагуу сумын хэмжээнд хэрэгжүүлнэ.

3.3.8. Сумын цагдаагийн хэсгийн алба хаагчдын ажиллаж, амьдрах хэвийн үйл ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх зорилгоор, шаардлагатай зардлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, тэдний үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллана.

3.3.9 Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 66 хүний нөөцийг жил бүр тодотгон шинэчлэж зориулалтын хувцас, тоног хэрэгсэлээр бүрэн хангаж, гамшигтай тэмцэх чадавхийг сайжруулан дадлага сургууль, үзлэг зохион байгуулна.

### **Гадаад бодлого**

Зорилго: Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хөрш орнуудтай салбар бүрийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилт: 3.4.

Арга хэмжээ:

3.4.1. Гадаад хамтын ажиллагаатай муж, хот, тосгон олон улсын төслийн байгууллагатай түншлэх асуудлыг судлан хамтран ажиллах

### **Батлан хамгаалах**

Зорилго: Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын ажлын уялдаа холбоог ханган орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, цэргийн албыг иргэний төлөвшил, эх оронч үзэл хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт: 3.5. Батлан хамгаалах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн биелэлтийг хангах ажлыг тайван болон онцгой нөхцлийн үед хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ:

3.5.1 Батлан хамгаалах салбарын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

3.5.2 Цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар чөлөөлөгдсөн иргэдийг ээлжит цэрэг татлагын хооронд эрүүлжүүлэх ажлыг эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

### **Шилэн тендер:**

Зорилго: Тухайн онд хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээ болон шилэн тендерийг 2021 онд 100% цахимжуулах.

Зорилт: 3.6. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангах үүднээс санал авсан иргэдийн тоог жил бүр нэмэгдүүлэх

3.6.1. Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

3.6.2. Сумын бүх төрийн байгууллагуудын “Шилэн данс”-ыг хөтлүүлж, мэдээллэнэ.

### **ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭР**

Зорилго: Дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх, байгаль, эдийн засгийн эрсдэл даах чадавхитай уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуйн салбарыг орон нутагт төлөвшүүлнэ

4.1. Зорилт: Малын чанар, ашиг шимийг сайжруулж, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлнэ.

Арга хэмжээ:

4.1.1. Үхэр сүргийг “Дорнод монголын мухар улаан” үүлдрээр сайжруулна.

4.1.2. Мал сүрэгт эзлэх өндөр ашиг шимт малын тоог өсгөх, үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийн гарцыг нэмэгдүүлнэ.

4.1.3. Хээлтүүлэгч сүргийг бүртгэлжүүлж, мэдээллийн санд оруулна.

4.1.4. Малчдын залуу халааг бэлтгэхэд хувь нэмрээ оруулж байгаа тэргүүний малчдыг урамшуулах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.1.5. Байгалийн аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийг малчид, иргэдэд шуурхай дамжуулах сэрэмжлүүлэх МАСС МЕССЕЖ үйлчилгээг малчин бүх өрхөд хүргэх, хөрөнгийн асуудлыг 100 хувь шийдвэрлэнэ.

Зорилт: 4.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих замаар малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

4.2.1. Орон нутгийн онцлогт суурилсан нэрийн бүтээгдэхүүнийг бий болгох.

4.2.2. Ноос, арьс шир боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийн хоршин ажиллах санал санаачилгыг дэмжинэ.

4.2.3. Үндэсний үйлдвэрүүдэд чанар, стандартын шаардлага хангасан түүхий эд нийлүүлсэн малчдыг урамшуулалд хамруулах ажлыг зохион байгуулна.

4.2.4. Мал нядалгааны нэгдсэн цэг байгуулна.

Зорилт. 4.3. Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна.

Арга хэмжээ

4.3.1. Бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготонотой тэмцэх ажлыг зохион байгуулна.

4.3.2. Төр, хувийн хэвшлийн хөрөнгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

4.3.3. Бэлчээрийн ургамал тариалах төсөл хөтөлбөрийг бодлогоор дэмжинэ.

4.3.4 1, 2, 3-р багуудад усны хайгуул хийлгэх энгийн уурхайн худаг засварлах, тохижуулах, нэмэгдүүлэх

Зорилт: 4.4. Мал эмнэлэгийн ажил, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулж ажиллах.

Арга хэмжээ:

4.4.1. Малын эмч мэргэжилтэн бэлтгэн хүний нөөцийг бүрдүүлэн чадавхжуулна.

4.4.2. Орон нутагт гардаг мал амьтны шимэгчтэх өвчний шалтгаан нөхцлийг тодорхойлж, оношлуулан эмчлэх, эрүүлжүүлэх ажлыг графикайн дагуу зохион байгуулна.

4.4.3. Энгэр - Ус 2 дугаар багт малчдын дунд мал угаалгын ванн барина.

4.4.4. Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийг тарилга үзлэгийн зөөврийн хашаатай болгоно.

4.4.5. Малын гоц халдварт , халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулахад Багийн засаг дарга нар, МЭҮНэгж, иргэд, малчдын уялдаа холбоог сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэн малын өвчлөлийг бууруулна.

4.4.6. Мал мах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарт тавих хяналтыг сайжруулж, цахим системийн ашиглалтыг сайжруулна.

4.4.7. Вакцин хадгалах хөргүүртэй болгох

4.4.8 МЭҮНэгжүүд мал эмнэлгийн био хаягдлын зуух, устгалын цэг бий болгоно.

#### Газар зохион байгуулалт

Зорилт: 4.5. Хил залгаа болон орон нутаг дахь газар нутгийн асуудлыг шийдвэрлэнэ.

Арга хэмжээ:

4.5.1. Говь-угтаал, Өндөршил, Гурвансайхан, Цагаандэлгэр, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумдтай хил залгаа айл өрхүүдийн өвөлжөө хаваржааны газруудыг хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.5.2. Өмчлөлийн газрыг хуулийн дагуу шийдвэрлэх

4.5.3. Өвөлжөө, хаваржаа бэлчээр ашиглалтын журам шинэчлэн боловсронгуй болгох

### ТАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

#### Санхүү, төсвийн зохицуулалт

Зорилго: Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулах замаар татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэж, татварын орлогын бааз 2020 онд 423,7 мянган төгрөг байсныг жил бүр 1 хувиар нэмэгдүүлж, 2024 онд 550,0 мянган төгрөгт хүргэнэ.

Зорилт: 5.1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааны цахимжуулалт 2020 онд 90 хувь байсныг 2024 онд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.1.1 Татварын тайлан буюу цахимаар ирүүлбэл зохих тайлангийн хувийг нэмэгдүүлнэ.

5.1.2 Улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жил бүр 100 хувь биелүүлнэ.

5.1.3. Татварын орлого АМНАТ ААН-үүдийг орон нутгийн харъяат болгох

Зорилт: 5.2. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авалтанд орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2020 онд 30 байсныг 2024 онд 40 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.2.1. Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэб сайт болон цахим хуудсаар тухай бүр мэдээлнэ

5.2.2.Төрийн худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдэд төрийн захиргааны албан хаагчид, иргэдийн төлөөллийг А-3 сургалтанд хамруулна.

Зорилт: 5.3 Төсвийн хөрөнгийг орон нутгийн хөгжилд чиглүүлэн үр ашигтай, хариуцлагатай зарцуулах бодлого баримтална.

Арга хэмжээ:



5.3.1. Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулна.

5.3.2 Улс, аймаг, сумын төсөв, хөрөнгө оруулалт, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хандив тусламжаар бүтээн байгуулж, худалдан авч, шилжүүлэн өгсөн орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар гарсан шийдвэрийг баримтлан ажиллаж, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга, бусад байгууллагууд орон нутгийн өмчийн өмчлөл, ашиглалт, хамгаалалт, хадгалалтад нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэн, эд хариуцагч бүртэй эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулан ажиллах тогтолцоог бүрдүүлнэ.

5.3.3 Төсвийн ил тод нээлттэй, хэмнэлттэй үр ашигтай байдлыг хангаж, хариуцлага дэг журмыг сахиулан ажиллана.

Зорилт: 5.4. Хүний нөөцийн хангалтыг 2020 онд 50 хувь байсныг 2024 он гэхэд 100 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

5.4.1 Санхүүгийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх, ажлын ачааллыг тэгш хуваарилах

5.4.2 Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэстэй хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай санхүүгийн ажилтны хангалтыг нэмэгдүүлэх, мэргэжүүлэх

### **Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно**

Зорилго: Байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын өвийг түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Зорилт 5.5: Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Арга хэмжээ:

5.5.1. Сумын аялал жуулчлалын төлөвлөгөөг боловсруулна.

5.5.2. Аргийн хад байгалийн үзэсгэлэнт газарт “Нүгнээч” жуулчны бааз байгуулна.

5.5.3 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэд, ААН-г дэмжин ажиллана.

### **Төр, хувийн хэвшлийн түншлэл**

Зорилго: Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

Зорилт: 5.6. Орон нутгийн худалдаа үйлчилгээ, өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин хөгжүүлж, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.

Арга хэмжээ:

5.6.1. Орон нутагт нэн шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэдийг бодлогоор дэмжиж ажиллана.

5.6.2. Газар тариалан эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар хүн амын хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.

5.6.3. Орон нутгийн хүнс, газар тариалан, өрхийн болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, брэнд бүтээгдэхүүнийг бий болгоно.

5.6.4. Худалдаа, хүнс, нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, холбогдох стандартыг мөрдүүлж ажиллах.

### **Уул уурхай, хүнд үйлдвэр**

Зорилго: Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн нүүрс, жонш, төмөр зэрэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг орон нутгаас дэмжиж, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоно.

Зорилт: 5.7. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

5.7.1. Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг орон нутагт хуулийн дагуу дэмжиж ажиллана.

5.7.2. Уул уурхайн баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж /хүнсний хангамж, ажиллах хүч болон туслах гүйцэтгэх бусад үйл ажиллагаа г.м/ орон нутагтай хамтран тогтвортой аюулгүй ажлын байраар хангадаг тогтолцоог бүрдүүлнэ.

5.7.2. Уул уурхай болон бичил уурхай зориулалтаар ашиглаж гар аргаар ашигт малтмал олборлосоны улмаас эвдэрсэн газрын судалгааг гаргаж нөхөн сэргээх ажлыг зохион байгуулна.

Зорилт 5.8. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайн үйл ажиллагааг дэмжинэ.

Арга хэмжээ :

5.8.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компанийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.8.2. Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авч ажиллана. Аймгийн ИТХ, сумын ИТХ-аар баталсан уул уурхайн замын тээврийг маршрутын дагуу сайжруулан ашиглуулах

5.8.3. Орон нутагт замын маршрутын журам батлуулах

## **ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ**

### **Ногоон хөгжлийн бодлого**

Зорилго 6. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт: 6.1. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ:

6.1.1 Агаарын бохирдлыг бууруулах өрхийн ухаалаг хэрэглээг бий болгох, цахилгаан халаалтыг дэмжих, нэгтсэн халаалтын зуухыг албан байгууллага, ААНэгж, айл өрхийг холбох, утаа баригчтай болгох зэрэг арга хэмжээг судалж хэрэгжүүлнэ.

Зорилт 6.2. Усны бохирдол, хомсдоос сэргийлэх, хүн амыг баталгаат ундны усаар хангах нэгдсэн менежментийг сайжруулна. /2020 онд 2 худаг цэвэршүүлэх төхөөрөмж ухаалаг смарт карттай болсон 2024 онд 4 худаг болгох.

Арга хэмжээ:

6.2.1. Төв суурин газрын ундны усны чанар стандартыг сайжруулан цэвэршүүлэх төхөөрөмжийг ус хангамжийн 4 эх үүсвэрт суурилуулна.

6.2.2. Булаг шандны эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулна.

6.2.3. Газрын доорх усны чанар, нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.2.4. Ундны усыг чанарын шинжилгээнд хамруулна.

6.2.5. Сумын нутаг дэвсгэрт усны хайгуулын нэгдсэн судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

6.2.6. Булаг шанд, усыг түшиглэн хур тунадас, цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулна./ Сэрвэнгийн булаг зураг төсөв хийгдсэн байгаа/

Зорилт : 6.3. Хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн үр дүнтэй төсөл хэрэгжүүлж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. 2020 онд сумын төвд 6,2 га байсныг 2024 онд 9 га-д хүргэнэ.

Арга хэмжээ :

6.3.1. Сумын хэмжээнд 2,8 га талбайд ойн зурвас байгуулах.

6.3.2. Уул уурхайн ААН-н ногоон байгууламжийг нэмэгдүүлж биологийн нөхөн сэрээлтийг хийлгэх

6.3.3. Зөв дадал – Ногоон ирээдүй” уул уурхайн ААН-н нэрэмжит “Шилдэг тохижилт ногоон байгууламж” цэцэрлэгт хүрээлэнтэй болох

6.3.4. Албан байгууллага, ААН, айл өрх бүр ногоон байгууламж нэмэгдүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.3.5. Цэцэрлэгт хүрээлэнгийн усан оргилуур болон гэрэлтүүлэгийн тохижилтийн ажлыг жил бүр нэмэгдүүлнэ.

Зорилт : 6.4. Ан амьтдын амьдрах орчныг тэтгэх, сайжруулах ая тухтай орчинг бий болгоход иргэн аж ахуйн нэгж, нөхөрлөлийн оролцоог нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ :

6.4.1. Дэд бүтэц, бүтээн байгуулалт аялал жуучлалын төслүүдийг хэрэгжүүлэхэд ан амьтдад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

6.4.2. Зэрлэг амьтдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулж, био-техникийн арга хэмжээ авна.

6.4.2. Тарвага хамгаалах арга хэмжээг авч тоо толгойг нэмэгдүүлнэ.

6.4.3. Сумын хэмжээнд амьтан, ургамлын нарийвчилсан тооллогыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн нөөцийг тогтооно

Зорилт 6.5. Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулж, нэгдсэн журам боловсруулж мөрдүүлж ажиллана.

Арга хэмжээ :

6.5.1. Хог хаягдлын цэгт дахин төлөвлөлт мэргэжлийн байгууллагатай хамтран хийнэ.

6.5.2. Ангилан ялгах хогийн савтай болно.

6.5.3. Төв суурин газрын төвлөрсөн хогийн цэгийн талбайг шууж, хашаажуулах.

6.5.4. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажилуулна.

Зорилт 6.6. Эзэн холбогдогчгүй болон нөхөн сэргээлт хийгээгүй газрыг нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ :

6.6.1. Эзэн холбогдогчгүй эвдэрсэн газар , нөхөн сэргээлт хийгээгүй газрын тооллого, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж, нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийнэ.

6.6.2. Уул уурхайн болон бусад үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.

6.6.3. Байгаль орчинд учирсан хохирлын үнэлгээ тооцуулна.

Зорилт: 6.7. Сайн дурын байгаль хамгаалагчдыг дэмжиж, байгаль орчны чиглэлээр ажиллах иргэд, олон нийтийн оролцоог идэвхжүүлнэ.

Арга хэмжээ

6.7.1. Иргэний нийгмийн байгууллагатай хамтран иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.

6.7.2. Байгаль хамгаалах сайн дурын идэвхтэн байгаль хамгаалагчдыг ажиллуулж, урамшуулна.

Зорилго: Аймаг, сумын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.

Зорилт: 6.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 2020 онд 12.5 хувь байсныг 2024 онд 20 хувь, аймгийн тусгай хамгаалалт 2020 8.7 хувь 2024 онд 10 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ:

6.8.1.Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэн мэдээллийн санд бүртгүүлэн баталгаажуулж, хамгаалалтыг сайжруулна.

6.8.2. Газар доорх усны орд, усан сан бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

Зорилт: 6.9 Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангагдсан айл өрх ААН-н эзлэх хувь 2020 онд 2,1 % байсныг 2024 онд 5 хувьд хүргэнэ.

Арга хэмжээ: 6.9.1. Айл өрх, албан байгууллага, ААН-н болон уул уурхайн бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлэх.

### **Хариуцлагатай уул уурхай**

Зорилго: Хариуцлагатай уул уурхай хөгжсөнөөр орон нутгийн байгууллагуудын идэвхитэй оролцоог бүх түвшинд хангаж ажиллах, шийдвэр гарахад иргэн олон нийт, сум орны төр засгийн байр суурийг тусган, оролцоог тал бүртээ ашигтайгаар урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Зорилт: 6.10. Аймаг, сумтай хамтран ажиллах 3 талт гэрээг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй байгуулна.

Арга хэмжээ:

6.10.1. Хөрөнгө оруулагчдын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж орон нутгийн иргэдийг оролцуулна.

6.10.2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын зөвшөөрөл олгоход багийн ИНХурлаас санал өгөх тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу шуурхай олгоход анхаарч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтэд тавина.

6.10.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд жилд 2-оос доошгүй удаа нутгийн захиргааны болон хууль хяналтын байгууллагуудын нэгдсэн

шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж тодорхой ажил зохион байгуулна.

6.10.4. Бичил уурхай эрхлэгчдийг осол аюулгүй, байгаль орчинд сөрөг нөлөө багатай ажиллуулж, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргийг өндөржүүлэх. Гэрээг жил бүр дүгнэнэ.

6.10.5. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ээр жил бүр техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үе шаттай хийлгэх, дүйцүүлэх нөхөн сэргээлтийг тогтмол хийлгэж хэвшүүлнэ.

6.10.6 Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа уул уурхайн компаний тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## **ДОЛОО. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

Зорилго: Иргэдийн ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг бүрдэнэ.

Зорилт: 7.1. Гэр хорооллын дэд бүтцийг нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

7.1.1 Суманд “Жишиг гудамж”, “Шинэ хороолол”-ыг иргэдийн оролцоотой байгуулж дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.

7.1.2 Малчин хорооллыг иргэдийн саналын дагуу хуульд нийцүүлэн байгуулна.

### **Орон нутгийн хөгжил**

Зорилт: 7.2. Орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.

7.2.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болно.

7.2.2. Сумын төвийг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбож барилгын дотор сантехникийн засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.

7.2.3. Нутгийн удирдлагын ордон шинээр барина.

7.2.4. Бусад нийтийн эзэмшлийн дэд бүтцийг сайжруулах шинэ хорооллын 0,4 шугам тавина.

7.2.5. Дотуур байрны засварын ажил зохион байгуулна.

7.2.6. Эрүүл мэндийн төвийн хуучин амбулаторийн барилгын их засвар хийж тохижуулна.

7.2.7. Шинээр 40 айлын орон сууц барина.

7.2.8. Сумын ёслол хүндэтгэлийн өргөөг иж бүрэн тохижилттой болгож байнгын ажиллагаатай болгоно.

7.2.9. Сумын нутаг дэвсгэр дэх гол болон төв замуудад авто замын тэмдэглэгээ хийх ажлыг зохион байгуулах

7.2.10. Багш хөгжлийн төвийн тохижуулалтыг хийнэ.

7.2.11. Цэцэрлэгийн хүүхдийн “Ёс заншил”-ын өргөөг байгуулна.

7.2.12. Хогны машинтай болно.

7.2.13. Нийтийн халуун усны газрыг сэргээн засварлах, тохижуулах

7.2.14. Хүүхэд хөгжлийн төвтэй болно.

7.2.15. Нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн урсгал засвар, арчилгаа хийх зардал

7.2.16. ЭМТ-ийн мэдээ, мэдээллийн танхимын тоног төхөөрөмж

7.2.17. Булгийн эх хашиж хамгаалана

7.2.18. Сумын соёлын төвийн засварын ажлыг хийнэ.

7.2.19. Төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор төрийн албан хаагчдыг орон сууцжуулна.

7.2.20. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний машинтай болно.

7.2.21. Стандартын шаардлага хангасан 250 хүний суудалтай, соёлын төвийн шинэ барилга ашиглалтанд оруулна.

7.2.22. Ундны усны чанар стандартыг сайжруулан, цэвэршүүлэх төхөөрөмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг тохижуулна.

7.2.23. Угталт, үдэлтийн хаалганы тохижилтыг сайжруулна.

7.2.24. Соёлын төвийн дотор монтажны засвар ажлыг хийнэ.

7.2.25. Моломжамцын нэрэмжит гадаа талбайн бий болгоно.

7.2.26. Малгай цагаан овоон дээр нутаг орны түүхт цэргийн тухай дурсгалт хөшөө, үдэлт, угталтын талбайг бий болгоно.

## **НАЙМ: АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ ИРГЭН**

Зорилго: Ажилгүй иргэдийг ажлын байраар хангаж, орлогыг нэмэгдүүлэх

Зорилт: 8.1. Сумын хэмжээнд хэрэгжүүлж бүтээн байгуулалтын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэ ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшинг тогтмол нэмэгдүүлнэ.

Арга хэмжээ:

8.1.1 Орлого багатай болон эмзэг бүлгийн өрхийн гишүүдийг төрөл бүрийн сургалтанд хамруулж ажлын байранд зуучилж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

8.1.2 Ажилгүйдлийг бууруулах бодлогын баримт бичиг боловсруулан, батлуулж хэрэгжүүлнэ.

8.1.3. Махны чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй байгуулна.

8.1.4 Эрчимжсэн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах санал санаачилгыг дэмжинэ.

8.1.5 Газар тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулж тариалалтыг нэмэгдүүлнэ.

8.1.6 Уул уурхайд баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах

8.1.7. Ашигт малтмалын бүтээгдэхүүний тээврийг орон нутгийн жолооч, аж ахуйн нэгжээр хийлгэх чиглэл баримтлан ажиллана.

8 бүлэг 254 заалттай